



ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2025.01.08 № 01/12

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Харьяа байгууллагын 2024 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд салбарын хяналт, шинжилгээний үнэлгээний баг томилон ажиллуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгүүллээ.

Цаашид Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, түүний хавсралтуудыг сайтар судлан ойлгож, чанд мөрдөж хэрэгжүүлэн, дараах илрүүлсэн нийтлэг зөрчил, санал, зөвлөмжүүдийг үнэлгээний заалт тус бүрд анхаарч, засаж залруулан алдаа, дутагдал, зөрчил гаргахгүй ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилт, гүйцэтгэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшин зэрэг нь өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой, хэмжигдэхүйц байх нь гүйцэтгэл үнэн бодиттой болж, үнэлгээ хийхэд ойлгомжтой, хялбар болох тул төлөвлөгөөг сайн боловсруулах;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг бичиг хэргийн стандартын дагуу боловсруулахад анхаарч ажиллах;

3. Хэрэгжилт буюу гүйцэтгэлийг Засгийн газрын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" гэсэн бүлгийн томъёо болон тодорхой заасан хувиар тооцож гаргах;

4. Удирдах албан тушаалтнууд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн сургалт, семинарын гэрчилгээ, бусад баримтуудаар баталгаажуулж хавсаргах;

5. Журмын 6.8-д "Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг 2000 мянган тэмдэгтэд багтаана" гэж заасныг баримтлаагүй. Мөн оновчтой, хүрсэн үр нөлөөг тодорхой тоон үзүүлэлтээр нотолж, үнэн зөв бичих, хүснэгтэн тайланд зураг, график оруулахгүй байх;

Дэлгэрэнгүй зөвлөмжийг хавсаргав
Хавсралт Б.хуудастай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ОЮУНЖАРГАЛ

152250003
d:\2025\toot\01.08-12.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
01/12 дугаар албан бичгийн хавсралт



Харьяа байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээнд жилийн эцсийн
тайланд гүйцэтгэх хяналт-шинжилгээ, үнэлгээ

Д/д	Харьяа байгууллага	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Зөрчил/Санал	Тайлан-гийн үнэлгээ	Тайлангийн үнэлгээ+ ур чадвар+ хандлага, ёс зүйн
		Дугаар			
1	2	3	4	5	6
1	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	-3.2, 3.3, 6.1, 8.7, 9.1, 9.2, 11.1, 11.2, 11.6, 15.6, 19.7, 19.10, 8.6, 13.10, 20.1, -8.8, 10.2, -11.4, 11.5	-Арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй. -Арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн. -Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин уялдаагүй.	97.7	94.2
2	Нислэгийн цаг уурын төв	2.1	Арга хэмжээн дээр хүрэх түвшиндээ хүрээгүй тул 90% болгож бууруулсан. Зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг буруу тодорхойлсон байна.	98.3	97.4
3	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори		Зарим шалгуур үзүүлэлт дээр анхаарах мөн хүрсэн түвшиндээ хүрсэн үгүйг тодорхой тоон утгатай бичиж тайлагнах	99.9	98.9
4	Архангай-УЦУОШТ	2.1, 3.3, 4.2	Стратеги төлөвлөгөөтэйгөө хэрэгжүүлэх арга хэмжээгээ уялдуулах /стратеги төлөвлөгөө	97.8	97.2

1	2	3	4	5	6
			боловсруулах журамд “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна” гэж заасан/ Биелэлтийг 2000 тэмдэгтэд багтаан оновчтой, хүрсэн үр нөлөөг тодорхой тоон үзүүлэлтээр нотолж, зөв бичих дүрмийн алдаагүй бичих.		
5	Баян-Өлгий- УЦУОШТ	2.1, 2.4, 3.1, 3.6, 5.6,9, 11-13	Арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхой хэмжигдэхүйц бичих. 4.9, 17 -үнэлэх боломжгүй.	96.86	97
6	Баянхонгор- УЦУОШТ	1.3,1.9,1.10,2.2,2.3,2.4,2.2.1-2.2.5	Арга хэмжээнүүдийн Шалгуур үзүүлэлт, Зорилтот түвшин, Хүрэх түвшинг буруу тодорхойлсон.1.9 Үнэлэх боломжгүй. 1.10 суурь түвшин зорилтот түвшин ойлгомжгүй. 2.2 зорилтот түвшнээс 1.57-оор буурсан. 2.3 Урьдчилан мэдээлэх ажлын үзүүлэлт улсын дунджаар өмнөх оноос 4.0 хувиар буурсан байна. 2.4 Жилийн эцсийн байдлаар нислэгийн үйлчилгээний дүн 3.8 хувиар буурсан байна. 2.2.1 -2.2.5 хүртэл суурь түвшин дээр Нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт 100%, зорилтот түвшин дээр 50 хувь гэж түвшинг буруу тодорхойлсон. Баримт бичгийн стандарт MNS5140-2:2021-ийг баримтлах. Журмын 6,8-д “Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагат тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг 2000 мянган тэмдэгтэд багтаана” гэж заасныг	97.7	96.9

1	2	3	4	5	6
			баримтлаагүй. Жишээ нь 1.3 гэхэд бүтэн 5 хуудас бичвэр болсон.		
7	Булган- УЦУОШТ	1	1 дээр ямар ч ойлгомжгүй байсан, зорилтод түвшнээ зөв тодорхойлох, зорилтод түвшин дээрээ 100 % гэсэн хэр нь хүрсэн түвшин дээрээ хувь байхгүй, яаж хүрсэн түвшнээ тодорхойлоод байгаа нь тодорхой бус байна.	98	93.1
8	Говь-Алтай- УЦУОШТ	1.4 , 5.2 3.2, 3.4, 3.4, 4,1 4.2, 11.3 7, 7.1 9.1	-Зорилтод түвшинд хүрээгүй -Суурь түвшин, зорилтод түвшин буруу тодорхойлсон -Хүрсэн түвшин, хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тоон утгаар оруулах -2023 оны тайланг оруулсан байна, анхаарах -Орчны хяналт шинжилгээний дүн мэдээгээр үйлчилсэн төрөл тус бүрд жилд хийсэн хөтөлбөрт шинжилгээ, нэмэлт шинжилгээний тоон утгаар оруулах	98.3	97.3
9	Говьсүмбэр- УЦУОШТ	1.1.1 1.1.4 1.1.8	Цаг уурын шинжилгээний ажлын дүн буурсан. Чойр өртөө шалтгаангүйгээр 4 удаа мэдээ хоцорсон. Хагас жилийн хугацаанд 39 мэдээ хоцроосон нь мэдээгээ хяналтын хугацаанд бүрэн дамжуулах үүргээ биелүүлээгүй АМДС-ийн дүн буурсан	98.6	96.5
10	Дархан-Уул- УЦУОШТ	1.4, 5, 10, 12.8,	Арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхой хэмжигдэхүйц бичих	98.93	98.8
11	Дорноговь- УЦУОШТ	2.1, 2.5, 4.1,	Шалгуур үзүүлэлтээ буруу тодорхойлсон хүснэгтэн тайланд зураг график оруулахгүй байх, зарим арга хэмжээ нь зорилт байхгүй мөн зарим дээр суурь түвшин огт байхгүй байна. 3.7 огт хийгдээгүй ажил	97.7	95.3
12	Дорнод- УЦУОШТ	1.3, 2.1.1, 2.1.5, 2.4.1, 2.5.1, 2.6.2, 2.6.4	Зарим арга хэмжээний Шалгуур үзүүлэлт, Зорилтот түвшин, Хүрэх түвшингээ зарим зорилт дээр буруу тодорхойлсон. 1.3 Шалгуур	98.4	84.4

1	2	3	4	5	6
			үзүүлэлт дээр Аймгийн төвийн агаар дахь PM_{2.5} тоосонцрын жилийн дундаж агууламж /мкг/м³/, PM₁₀ тоосонцрын жилийн дундаж агууламж /мкг/м³/, суурь болон зорилтот түвшин дээр тоонууд тавьсан юуг илэрхийлж байгаа нь ойлгомжгүй. 2.1.1 Дундаж нь 96.5 хувьтай буюу зорилтот түвшиндээ 99.2% хүрээгүй. 2.1.5 Дундаж нь таарц 98.4 хувьтай буюу зорилтот түвшиндээ 99.8% хүрээгүй. 2.4.1 Жилийн эцсийн ерөнхий дүн 98.7 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар ахисан байгаа боловч зорилтот түвшин 99.1%-д хүрээгүй. 2.5.1 Хөрсний гүний автомат багажийг 2 жил дараалан байрлуулаагүй төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлээгүй. 2.6.2 Зорилтот түвшин 139 боловч 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 122 хэмжих хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийсэн. 2.6.4 5 өртөө, 8 харуулын хэмжих хэрэгсэлд харьцуулсан тоололт хийж гүйцэтгэсэн. Үлдсэн 3 харуулын хэмжих хэрэгсэлд хийх үзлэг оношилгоог ирэх оны төлөвлөгөөнд оруулна гэсэн. Зорилтот түвшин дээр тоог нь зааж өгөх.		
13	Дундговь- УЦУОШТ	2.1.2 2.2 2.8.2	Цаг агаарын мэдээг хяналтын хугацаанд бүрэн дамжуулах үүргээ биелүүлээгүй, мэдээ хоцролттой. Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилсэн. Ажлын ерөнхий дүн буурсан Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд зурган мэдээ оруулахгүй	98.3	95.1
14	Завхан- УЦУОШТ	2.7, 3.11,	Ихэнх арга хэмжээний шалгуур үзүүлэлтээ буруу тодорхойлсон 2.7, 3.11, зорилтод түвшинд хүрээгүй	97.6	97.9

1	2	3	4	5	6
15	Орхон- УЦУОШТ	2.1.4	Арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй.	99.8	96.7
16	Өвөрхангай- УЦУОШТ	1.4, 3, 6, 9.1.	Хэмжих шалгуур үзүүлэлтийг зөв, оновчтой тодорхойлох шаардлагатай. Цаашид Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулж хэвших /1 удаагийн мэдээ хоцроосон/	99.5	96.1
17	Өмнөговь- УЦУОШТ	1.4, 1.5, 1.8 1.7, 1.10 2.5, 2.6 1.5	-Хүрсэн түвшин, хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тоон утгаар оруулах - Тайлант хугацаанд мэдээд хоцроолгүй байх талаар анхаарах -2025 оны байгууллагын төлөвлөгөөний эхэнд оруулах, хүрэх түвшинг зөв тодорхойлох -Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг зөв тодорхойлох, хэдэн шинжилгээ хийсэн тоо, дүгнэлт гарах боломжгүй зөвхөн стандарттай харьцуулсан тайлан гарна. -Хүрсэн түвшин хэрэгжилтийн хэсэгт Төлөв байдлын тайлан орох шаардлагагүй, товч тодорхой тоо утгаар илэрхийлэн бичих. Биелэлтийг дүгнэх боломжгүй, хэт товчилж бичсэн байна.	98.9	97.8
18	Сүхбаатар- УЦУОШТ	4.1, 5.1.2, 6.1, 7.1, 9.1, 10.1,	Төлөвлөлт дээр анхаарах шалгуур үзүүлэлт зорилтод түвшинг зөв тодорхойлох 4.1, 5.1.2, 6.1, 7.1, 9.1, 10.1, зорилтод түвшинд хүрээгүй 8.6 хийж эхлээгүй ажил	94	94.1
19	Сэлэнгэ- УЦУОШТ	1.1.1 1.1.3 1.1.4 1.1.5	Тайлангийн ихэнх хэсэг дээр хүрсэн түвшин тодорхой бус байна. 1.1.1, 1.1.3, 1.1.4, 1.1.5 дээр хүрсэн түвшиндээ хүрээгүй байна. 1.1.3-дээр зорилтод түвшин дээрээ тус бүр хувилсан хэр нь хүрсэн түвшин дээрээ тоо баримт байхгүй байна. Дараа жилийн тайлан дээрээ анхаарах.	98.2	95

1	2	3	4	5	6
20	Төв- УЦУОШТ	1,1.1.10, 2.1.1 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.9, 5.1.12, 5.1.14, 5.1.18, 5.1.15, 6.1.2, 6.1.3 1.1.11, 3.1.7, 4.1.4-9	ЗГ-ын 2020 оны 100 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын загварыг өөрчлөхгүй байх, зорилтууд суурь түшин, зорилтод түвшин байхгүй байна. -Хүрсэн түвшин, хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тоон утгаар оруулах -Шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг зөв тодорхойлох, -Суурь түвшин, зорилтод түвшин зөв тодорхойлох, үнэлж болохуйц байх.	98.8	93.7
21	Увс- УЦУОШТ	1.1, 1.2.1, 1.5, 1.6, 2.3, 3.3, 5.4.	хэмжих шалгуур үзүүлэлтийг зөв, оновчтой тодорхойлж, логик дэс дараалалтай, хүрсэн үр дүн, үр нөлөөг тодорхой бичих шаардлагатай.	97.8	97.5
22	Улаанбаатар- УЦУОШТ	1.2, 6, 10, 3.2, 3.5, 4.4, 4.12	Арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхой хэмжигдэхүйц бичих	98.06	98.06
23	Ховд- УЦУОШТ	2.2	Зорилтод түвшиндээ хүрээгүй байхад үнэлэлт өндөр байна. цаашдаа анхаарах	98.8	98.1
24	Хөвсгөл- УЦУОШТ	2.1.1-2.1.3 2.1.8	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц буурсан. ААМО мэдээ чанар буурсан. Баримт бичгийн стандарт MNS5140-2:2021-ийг баримтлах. Журмын 6,8-д “Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг 2000 мянган тэмдэгтэд багтаана” гэж заасныг баримтлаагүй. Жишээ нь 3.3.2 гэхэд бүтэн 5 хуудас бичвэр болсон.	99.4	96.2
25	Хэнтий- УЦУОШТ	1.1.1, 1.1.2, 2.2.3, 2.2.4, 2.6.2	Арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй.	98.8	96

----oOo----

Жишээ-Төлөвлөгөө

..... АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
-----	---	-------	------------------	--------------	-----------------	-----------------------	---------------

1	2	3	4	5	6	7	8
---	---	---	---	---	---	---	---

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

Ус цаг уур орчны шижилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний Зорилт-2-ын 2.1, Зорилт-5-ын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, Зорилт-6-ын 6.1, , 2018 оны А/222 тушаал Агаарын чанарын мэдээ гаргах журам, 2018 оны А/387 тушаал Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журам, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны А-02, Монгол улсын Засгийн газрын 2015/286-Журам, жагсаалт, хуваарь батлах тухай , Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А-02 тушаал “Хөтөлбөр батлах тухай”, Ус цаг уур орчны шижилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт-3-ын 3.2, хүрээнд:

	Зорилт-1.....	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
1.	Арга хэмжээ-2.1. Цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт технологид хяналт тавих, улсын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, мэргэжил арга зүй, удирдлагаар хангах	Улсын төсөв	Цаг уурын өртөө 9, харуул 7 хөтөлбөрийн дагуу	2023 онд улсын хэмжээнд тайлангийн ирц-100%, шүүмж шалгалтын чанар-99.2%-д ажилласан.	Цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 онд т/и-100% ш/ш-99.3%-аас дээш хүргэх ба урд жилийн ажлын үзүүлэлтийг хадгалан ажиллана.	2023-XII 2024-XI	ЦУОТХ
2.	Арга хэмжээ-2.2. Цаг уурын ажиглалт хэмжлийн мэдээг хяналтын системээр шуурхай дамжуулах, хяналт тавих	Улсын төсөв	Шуурхай мэдээний чанар 90.0% дээш	2023 онд цаг уурын өртөө, цаг уурын харуулуудын мэдээ зохиолтыг 91.31% хүрсэн	Нийт салбаруудын мэдээ зохиолтыг 2024 онд 93.45% хүргэж ажиллана.	2023-XII 2024-XI	ЦУОТХ

..... АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	Зорилт-1.....	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
1.	Арга хэмжээ-2.1. Цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт технологид хяналт тавих, улсын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, мэргэжил арга зүй, удирдлагаар хангах	Улсын төсөв	Цаг уурын өртөө 9, харуул 7 хөтөлбөрийн дагуу хувиар	2023 онд улсын хэмжээнд тайлангийн ирц-100%, шүүмж шалгалтын чанар-99.2%-д ажилласан.	Цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 онд т/и-100% ш/ш-99.3%-аас дээш хүргэх ба урд жилийн ажлын үзүүлэлтийг хадгалан ажиллана.	Цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 онд т/и-100% ш/ш-99.3%-д хүргэж ажилласан. - Цаг уурын 9 өртөөний хур тунадасны харьцуулсан тоололтыг автоматаар хэмжсэн, тунадасыг хэмжүүрийн аягаар хэмжсэн хэмжилтэнд харьцуулалт хийлгэж, тайланг хугацаанд нь хүргүүлсэн. -Мөн 2024 оны 1-6 саруудын цаг уурын өртөө, харуулын цаг уурын ажиглалтанд шүүмж шалгалтаар илэрсэн эргэлзээтэй болон гологдол ажиглалтын тайланг хүргүүлсэн.	100
2.	Арга хэмжээ-2.1. Цаг уурын ажиглалт хэмжлийн мэдээг хяналтын системээр шуурхай дамжуулах, хяналт тавих	Улсын төсөв	Шуурхай мэдээний чанар 90.0% дээш хувиар	2023 онд цаг уурын өртөө, цаг уурын харуулуудын мэдээ зохиолтыг 91.31% хүрсэн	Нийт салбаруудын мэдээ зохиолтыг 2024 онд 93.45% хүргэж ажиллана.	Нийт салбаруудын өдөр тутамын шуурхай мэдээлэлд цаг уурын салбарын инженер, техникчид тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Нийт салбаруудын 2024 оны мэдээ зохиолт-91.18%-тай ажилласан. Энэ онд ажил дүгнэх журам өөрчлөгдснөөс мэдээ зохиолтын дүн буурч, хүрэх түвшиндээ хүрээгүй.	90